



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/383

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 99 жилийн ойн хурдан морины уралдааны зам засах, наадмын талбай, аймгийн баяр наадмын төв цэнгэлдэх хүрээлэнгийн хашааны гаднах гарц, гарамыг байгуулах ажилд 3 500 000 төгрөг /Гурван сая таван зуу/ - ийг зарцуулсугай.

2. Дээрх төсөл арга хэмжээнд зарцуулагдах 3 500 000 төгрөг /Гурван сая таван зуу/-ийг аймгийн 2020 оны Замын сангийн хөрөнгө оруулалтын жагсаалтын 4.3 заалтад тусгагдсан “Аймгийн төвийн автозам нөхөх, уулзварын эргэлтийг өргөтгөх /Жаргалант сум/”-аас санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баяхсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

